

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/296/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НД	Нийгмийн Даатгал
ТӨҮГ	Төрийн Өмчийн Үйлдвэрийн Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 9/31

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ШИНЭЦЭЦЭГ
ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баянцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 19,822.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дараах асуудлуудыг хязгаарлалттай дүгнэлтийн үндэс гэж үзлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 3,160.1 мянган төгрөгийн хүнсний материалыг тоолж баталгаажуулаагүй.
- Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 6,358.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн.
- Хөрөнгийн элэгдэл тооцоолоогүй 9,634.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.
- Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж ирүүлээгүй.
- Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхийг хориглосон 669.7 мянган төгрөгийн бүтээгдэхүүн авч хэрэглэсэн.

019020262

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,772,827.74	51,506,839.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,651,784.18	26,429,096.94
312	Банканд байгаа бэлэн мөнгө	76,651,784.18	26,429,096.94
3121	Төгрөг	76,651,784.18	26,429,096.94
31211	Төрийн сангийн харилцах	76,651,784.18	26,429,096.94
33	АВЛАГА	166,601.16	00.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	166,601.16	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,954,442.40	25,077,742.40
351	Түүхий эд материал	3,919,674.40	3,919,674.40
35110	Тусгай зориулалттай материал	3,919,674.40	3,919,674.40
354	Хангамжийн материал	19,659,768.00	19,783,068.00
35410	Бичиг хэргийн материал	196,000.00	196,000.00
35420	Аж ахуйн материал	18,388,088.00	18,428,088.00
35460	Хүнсний материал	1,075,680.00	1,158,980.00
35600	Мал амьтад	1,375,000.00	1,375,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	137,877,262.34	128,698,445.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	137,877,262.34	128,698,445.93
392	Биет хөрөнгө	117,983,262.26	108,829,445.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	122,735,800.00	122,735,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,631,432.36)	(44,857,358.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,324,562.00	29,324,562.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,837,175.71)	(13,607,550.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,724,641.30	28,964,641.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,169,619.97)	(16,567,134.83)
39217	Ном	2,836,487.00	2,836,487.00
393	Биет бус хөрөнгө	19,894,000.08	19,869,000.12
39301	Программ хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(49,999.92)	(74,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,794,000.00	19,794,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	239,650,090.08	180,205,285.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,760,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,760,000.00
413	Өглөг	00.00	1,760,000.00
4136	Бусад өглөг	00.00	1,760,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,760,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	239,650,090.08	178,445,285.27
51	Засгийн газрын хувь оролцоо	239,650,090.08	178,445,285.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,510,974.00	135,510,974.00
51101	Өмч: - төрийн	135,510,974.00	135,510,974.00
512	Хуримтлагдсан үр дүн	92,401,252.89	31,196,448.08

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	92,401,252.89	92,401,252.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(61,204,804.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,737,863.19	11,737,863.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	239,650,090.08	180,205,285.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	387,922,450.00	285,932,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,478,650.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,478,650.00	00.00
120007	Навигацийн орлого	4,959,450.00	00.00
120008	Монгол банкны ашиг	1,519,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,057,500.00	285,932,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	260,973,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	260,973,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,386,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,197,800.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,197,800.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,859,700.00	24,959,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,859,700.00	24,959,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	322,324,497.23	347,137,104.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,324,497.23	347,137,104.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,400,759.53	347,124,739.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,898,652.05	223,848,745.54
210101	Үндсэн цалин	125,706,250.08	159,822,972.69
210102	Нэмэгдэл	31,624,685.18	54,998,224.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	13,567,716.79	9,027,548.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,301,490.11	27,810,723.70
210201	Тэтгэврийн даатгал	14,471,510.58	18,923,508.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,708,986.43	2,238,043.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,367,189.24	1,790,434.71
210204	Ажилгүйдлийн даатгал	335,830.67	436,950.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,417,973.19	4,421,786.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,344,985.00	24,446,934.72
210301	Гэрэл, цахилгаан	3,254,945.00	4,849,294.72
210302	Түлш, халаалт	16,990,040.00	19,432,640.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	165,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,260,695.00	2,811,650.00
210401	Бичиг хэрэг	121,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,689,350.00	2,651,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,401,250.00	160,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,048,495.00	00.00
2105	Нормативт зардал	40,748,625.50	41,925,869.16
210502	Хоол, хүнс	39,641,325.50	39,048,519.16

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,107,300.00	2,877,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,000.00	667,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,000.00	667,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,226,311.87	25,113,816.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,221,040.00	13,636,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,815,060.00	2,058,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,190,211.87	9,418,816.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,923,737.70	12,365.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,831,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,005,300.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,889,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,937,200.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,237.70	12,365.28
213304	Хөрөнгийн	92,237.70	12,365.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	65,597,952.77	(61,204,804.81)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,315,325.19	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,315,325.19	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,315,325.19)	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	64,282,627.58	(61,204,804.81)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	381,443,800.00	285,932,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	381,443,800.00	285,932,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	260,973,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	260,973,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,386,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,197,800.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,197,800.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,859,700.00	24,959,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,859,700.00	24,959,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,792,015.82	335,914,987.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,792,015.82	335,914,987.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,868,278.12	335,902,621.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,898,652.01	223,848,745.54
210101	Үндсэн цалин	125,706,250.04	159,822,972.69
210102	Нэмэгдэл	31,624,685.18	54,724,224.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	274,000.00
210104	Урамшуулал	13,567,716.79	9,027,548.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,468,091.31	27,810,723.70
210201	Тэтгэврийн даатгал	14,638,111.78	18,923,508.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,708,986.43	2,238,043.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,367,189.24	1,790,434.71
210204	Ажилгүйдлийн даатгал	335,830.67	436,950.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,417,973.19	4,421,786.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,344,985.00	24,446,934.72
210301	Гэрэл, цахилгаан	3,254,945.00	4,849,294.72
210302	Түлш, халаалт	16,990,040.00	19,432,640.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	165,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативт зардал	38,238,649.80	45,822,218.00
210502	Хоол, хүнс	38,238,649.80	45,822,218.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,000.00	667,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,000.00	667,000.00

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,142,400.00	12,807,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,642,400.00	10,748,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	2,058,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,923,737.70	12,365.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	92,237.70	12,365.28
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	92,237.70	12,365.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,831,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,005,300.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,889,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,937,200.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	76,651,784.18	(49,982,687.24)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн		240,000.00
	Хөрөнгийн зардал		240,000.00
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(240,000.00)
5	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
6	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	76,651,784.18	(50,222,687.24)
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	76,651,784.18
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,540,073.60	26,429,096.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	12,154,158.39	27,702,330.11	00.00	175,367,462.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	416,295.20	00.00	416,295.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,510,974.00	12,154,158.39	28,118,625.31	00.00	175,783,757.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	64,282,627.58	00.00	64,282,627.58
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	11,737,863.19	92,401,252.89	00.00	239,650,090.08
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	11,737,863.19	92,401,252.89	00.00	239,650,090.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,510,974.00	11,737,863.19	92,401,252.89	00.00	239,650,090.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(61,204,804.81)	00.00	(61,204,804.81)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	11,737,863.19	31,196,448.08	00.00	178,445,285.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		76,651,784.18	(76,651,784.18)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	337,624,800.00	311,195,687.24	26,429,112.76	92.17%
УРСГАЛ ЗАРДАЛ	337,624,800.00	311,195,687.24	26,429,112.76	92.17%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,624,800.00	311,195,687.24	26,429,112.76	92.17%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,342,400.00	223,848,745.54	20,493,654.46	91.61%
Үндсэн цалин	164,518,000.00	159,822,972.69	4,695,027.31	97.15%
Нэмэгдэл	70,739,700.00	54,724,224.73	16,015,475.27	77.36%
Унаа нөхөн олговор	00.00	274,000.00	(274,000.00)	
Урамшуулал	9,084,700.00	9,027,548.12	57,151.88	99.37%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	30,543,000.00	27,810,723.70	2,732,276.30	91.05%
Тэтгэврийн даатгал	20,769,100.00	18,923,508.72	1,845,591.28	91.11%
Тэтгэмжийн даатгал	2,443,300.00	2,238,043.40	205,256.60	91.60%
ҮОМШӨ-ний даатгал	1,954,900.00	1,790,434.71	164,465.29	91.59%
Ажилгүйдлийн даатгал	488,800.00	436,950.25	51,849.75	89.39%
Эрүүл мэндийн даатгал	4,886,900.00	4,421,786.62	465,113.38	90.48%
Норматив зардал	48,871,400.00	45,822,218.00	3,049,182.00	93.76%
Хоол, хүнс	48,871,400.00	45,822,218.00	3,049,182.00	93.76%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	686,200.00	667,000.00	19,200.00	97.20%
Мэдээллийн технологийн зардал	686,200.00	667,000.00	19,200.00	97.20%
Бараа үйлчилгээний бусад зардал	13,181,800.00	13,047,000.00	134,800.00	98.98%
Бараа үйлчилгээний бусад зардал	11,123,200.00	10,988,400.00	134,800.00	98.79%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,058,600.00	2,058,600.00		100.00%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	260,973,000.00	188,665,000.00	72,308,000.00	72.29%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	260,973,000.00	188,665,000.00	72,308,000.00	72.29%
Улсын төсвөөс санхүүжих	260,973,000.00	188,665,000.00	72,308,000.00	72.29%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		76,651,784.18	(76,651,784.18)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		26,429,096.94	(26,429,096.94)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00		100.00%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.00%
Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00		100.00%
Үйлчлэх ажилтан	9.00	9.00		100.00%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,593,300.00	24,959,300.00	1,634,000.00	93.86%
УРСГАЛ ЗАРДАЛ	26,593,300.00	24,959,300.00	1,634,000.00	93.86%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,593,300.00	24,946,934.72	1,646,365.28	93.81%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,093,300.00	24,446,934.72	1,646,365.28	93.69%
Гэрэл, цахилгаан	6,506,700.00	4,849,294.72	1,657,405.28	74.53%
Түлш, халаалт	19,386,600.00	19,432,640.00	(46,040.00)	100.24%
Цэвэр, бохир ус	200,000.00	165,000.00	35,000.00	82.50%
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	00.00	100.00%
Урсгал засвар	500,000.00	500,000.00	00.00	100.00%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	12,365.28	(12,365.28)	
Засгийн газар хоорондын шилжүүлэг	00.00	12,365.28	(12,365.28)	
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,365.28	(12,365.28)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,893,300.00	24,959,300.00	1,934,000.00	92.81%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,893,300.00	24,959,300.00	1,934,000.00	92.81%
Орон нутгийн төсвөөс	26,893,300.00	24,959,300.00	1,934,000.00	92.81%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00	00.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00		100.00%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.00%
Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00		100.00%
Үйлчлэх ажилтан	9.00	9.00		100.00%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхэд төвт сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэхийг эрхэмлэн, хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцсэн таатай орчныг бүрдүүлэн, хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэн “ЗӨВ МОНГОЛ” хүүхдийг төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон. Тус байгууллага нь анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, хэрэгжүүлэх 12 арга хэмжээтэй баталснаас нийт 93,5 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцогт сумын нь Хүүхдийн цэцэрлэг төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх

нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,795.7 мянган төгрөгөөр буюу 22,8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган.төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	76,651.8	26,429.1	(50,222.7)
Авлага	166.6		(166.6)
Бараа материал	24,954.4	27,078.9	2,124.5
Үндсэн хөрөнгө	137,877.3	131,346.4	(6,530.9)
Нийт хөрөнгө	239,650.1	184,854.4	(54,795.7)
Өр төлбөр		1,760.0	1,760.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	239,650.1	183,094.4	(56,555.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	239,650.1	184,854.4	(54,795.7)

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 50,222.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн зарцуулалттай холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 2,124.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 2,648.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 240.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдэж байгуулсан элэгдлийн дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,760.0 мянган төгрөг орон нутгийн тогтмол зардлын тодотгол нэмэгдээгүйтэй холбоотой гэрэл, цахилгааны өр үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 183,854.4 мянган төгрөг болж 54,795.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 290,188.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,893.3 мянган төгрөг, нийт 317,081.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 29,215.0 мянган төгрөгөөр бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 291,246.7 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 317,081.3 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 318,140.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 287,866.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулаагүй 1,934.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 265,785.2 мянган төгрөг буюу 92,2 хувьтай байна.

Хүснэгт 2.

					/мянган төгрөг/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71801- Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,213.4	1,213.4		100
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	47,208.2	44,159.1	3,049.1	93.5
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,648.6	2,648.6		100
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,029.3	1,029.3		100
1.5	Нүүдлийн бүлэгт хамруулах	5,335.2	4,401.7	933.5	82,5
1.6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,734.1	1,662.1	72.0	95,85
1.7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	207,131.0	185,724.1	21,406.9	89,67
1.8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	24,946.9	24,946.9		100
	Дүн	291,246.7	265,785.2	25,461.5	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 76,456.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 38,828.0 мянган төгрөг, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэлийн зардал 2,058.6 мянган төгрөг, гэрэл цахилгаан, түлш халаалтын зардал 26,093.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 8,290.5 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардал 686.0 мянган төгрөг, нийт 76,456.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар авахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 58,432.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Худалдан авалтын дүн буурсан нь хүүхдийн тоо буурсантай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 207,463.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,111.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,333.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан байр ашиглалттай холбоотой зардлыг 1,646.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 19.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 134.8 мянган төгрөг нийт 1,800.4 мянган төгрөгийг хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 171 мэдээллээс 165 мэдээллийн хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлсэн бол, 2 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	3,134.9	2	3,134.9	50%
Зөвлөмж	3	26,415.6	3	26,415.6	100%
Нийт дүн	5	29,550.5	5	29,550.5	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, хөрөнгө бараа материалын тооллогын үр дүнг хэлэлцэн баталгаажуулаагүй албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн дараагийн аудитаар анхаарал анхан шатны баримт хөтлөлт, ерөнхий журнал, гүйлгээ баланс, тайлангуудын хоорондын уялдаа холбоо, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг анхаарч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 180,344.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 180,344.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнгээс 21,919.2 мянган төгрөгийн зөрүүтэй нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

- Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайланг бэлтгээгүй 158,425.4 мянган төгрөгийн алдаа нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 19,822.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 19,822.9 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" г гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" э хүргүүлэв.

Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцэст 3,160.1 мянган төгрөгийн "Хүнсний материал"-ыг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Байгууллагын тооллогыг иж бүрэн хийж хэвших

2. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд үндсэн хөрөнгөнд 9,634.5 мянган төгрөгийн элэгдэл тооцоолоогүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.35 дугаар зүйлд "Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ.Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүртгэлтэй үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг хийж хэвших

3. Цахим и баримтын бүрдэл хангахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 6,358.0 мянган төгрөгийн и баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн байна.Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ гаргахдаа цахим и баримтын бүрдэл хангаж хэвших

4. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхийг хориглосон 669.7 мянган төгрөгийн хоол, хүнсний бүтээгдэхүүн авч хэрэглэсэн байна. Энэ нь Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн хамтарсан А/448, А/268 дугаартай "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай" тушаалд заасан болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоол хүнсийг бэлтгэхдээ хориглосон хүнсийг анхаарч аюулгүй байдлыг хангаж хэвших.

5. Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төгсөгчид болон иргэдээс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1-д "Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбогдох хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган.төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлан	1	21,919.2			1	21,919.2	1	21,919.2				
Хөрөнгийн тодруулга тайлангууд	1	158,425.4			1	158,425.4	1	158,425.4				
Дүн	2	180,344.6			2	180,344.6	2	180,344.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Хүүхдийн хүнсэнд хэрэглэхийг хориглосон хүнс бэлтгэсэн	1	669.7					1	669.7					

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүнсний материал тоолж баталгаажуулаагүй	1	3,160.1					1	3,160.1				
Элэгдэл тооцоогүй	1	9,634.5					1	9,634.5				
Цахим төлбөрийн баримтын бүрдэл хангаагүй	1	6,358.6					1	6,358.6				
Хандив тусламжийн орлогыг бүртгэхдээ сан байгуулж ажиллаагүй	1	-					1	-				
Хуулийн хугацаанд санхүүгийн тайлан бэлтгэж баталгаажуулаагүй	1	-							1	-		
Дүн	6	19,822.9					5	19,822.9	1	-		